



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 700

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 25 нэрийн, нийт 22,278,411.55 (хорин хоёр сая хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн
700 дугаар тогтоолын хавсралт

"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Гурил зурагч/ 1ц 12 кг	ш	1	7/6/2012	1,850,000.00	1,850,000.00	0
2	Тос сорогч	ш	2	3/31/2018	181,819.09	363,638.18	0
3	Мөсний машин	ш	1	3/23/2018	808,080.81	808,080.81	0
4	Печь 2017	ш	1	2/1/2017	272,545.45	272,545.45	0
5	Индукцийн плитка цэцэрлэг	ш	1	10/31/2015	389,900.00	389,900.00	0
6	Ус буцалгагч - 90009590	ш	1	10/31/2015	149,900.00	149,900.00	0
7	Хөргөгч Toshiba	ш	1	1/1/2005	406,746.38	406,746.38	0
8	Хатаагч DRGJ 62122	ш	1	7/5/2012	769,990.00	769,990.00	0
9	Махны машин 2017	ш	1	8/1/2017	1,454,545.45	1,454,545.45	0
10	Хатаагч машин	ш	1	7/4/2013	1,800,000.00	1,800,000.00	0
11	Угаалгын машин	ш	1	5/8/2013	3,740,000.00	3,740,000.00	0
12	Цохилттой дрилл 2017	ш	1	2/1/2017	130,000.00	130,000.00	0
13	Печь	ш	1	3/27/2018	123,884.30	123,884.30	0
14	Хивс угаагч / rgo advance /	ш	2	3/31/2018	495,040.49	990,080.98	0
15	Компьютер DELL 2015	ш	1	10/31/2015	2,049,800.00	2,049,800.00	0
16	3 үйлдэлтэй принтер 2015	ш	1	10/31/2015	329,900.00	329,900.00	0
17	Принтер HP1102	ш	2	5/8/2013	169,900.00	339,800.00	0
18	Санхүүгийн программ	ш	1	12/4/2007	1,595,000.00	1,595,000.00	0
19	Барилгын программ	ш	1	1/1/2009	750,000.00	750,000.00	0
20	Эстиматр Т-21 барилгын программ	ш	1	6/24/2009	142,300.00	142,300.00	0
21	Бичгийн ширээ	ш	3	4/18/2014	143,000.00	429,000.00	0
22	Шилэн хаалгатай шкаф	ш	1	4/18/2014	500,000.00	500,000.00	0

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
23	Хурлын сандал	ш	6	4/18/2014	75,000.00	450,000.00	0
24	Хурлын сандал	ш	6	3/28/2011	299,000.00	1,794,000.00	0
25	Хурлын ширээ	ш	1	4/18/2014	649,300.00	649,300.00	0
	НИЙТ ДҮН		40		19,275,651.97 (арван есөн сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун тавин нэгэн төгрөг ерэн долоон мөнгө)	22,278,411.55 (хорин хоёр сая хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг тавин таван мөнгө)	